

ЗЭЭЛДЭГЧИЙН ЗЭЭЛЖИХ ЧАДВАРЫН ЗЭРЭГЛЭЛ ТОГТООХ НӨХЦӨЛ, ШААРДЛАГА

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1. Энэхүү баримт бичгийн зорилго нь зээлдэгчийн зээлжих чадварын зэрэглэл тогтоох суурь нөхцөл, шаардлагыг зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдийн ашиглах зээлийн онооны загварыг боловсруулахад баримталж, үйл ажиллагаанд мөрдүүлэхэд оршино.
- 1.2. Монголбанкнаас тогтоосон зээлдэгчийн зээлжих чадварын зэрэглэл тогтоох нөхцөл, шаардлага нь зээлийн мэдээллийн ил тод байдал, олон улсын жишиг, зарчим болон Монгол Улсын хууль тогтоомжтой нийцтэй байна.

Хоёр. Нөхцөл, шаардлага

- 2.1. Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэгч нь дараах нөхцөл, шаардлагыг үндэслэн зээлдэгчийн зээлжих чадварын зэрэглэлийг тогтооно:
 - 2.1.1. Зээл, төлбөр төлөлтийн түүх;
 - 2.1.2. Зээл, төлбөрийн үлдэгдэл;
 - 2.1.3. Төлөгдөж дуусаагүй болон төлөгдөж дууссан зээл, төлбөрийн мэдээлэл;
 - 2.1.4. Сөрөг мэдээлэл (хугацаа хэтэрсэн зээл, төлбөрийн зөрчил, дампуурал);
 - 2.1.5. Эерэг мэдээлэл (хугацаанд нь төлсөн түүх, зээлийн эрхийн хэмжээ нэмэгдсэн гэх мэт).
- 2.2. Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэгч нь дараах мэдээллийг зээлдэгчийн зээлжих чадварын зэрэглэлийг тогтооход ашиглахыг хориглоно:
 - 2.2.1. хүн, хуулийн этгээдийг гадуурхсан мэдээлэл;
 - 2.2.2. нас, хүйс, гэрлэлтийн байдал;
 - 2.2.3. иргэний харьяалал, цагаачийн статус;
 - 2.2.4. хөгжлийн бэрхшээл, эрүүл мэндийн байдал, түүх, эмнэлгийн үйлчилгээний мэдээлэл;
 - 2.2.5. биометрик мэдээлэл;
 - 2.2.6. зээлдэгчийн зөвшөөрөлгүй цуглуулсан болон авсан мэдээлэл;
 - 2.2.7. албан ёсны бус эх сурвалжаас цуглуулсан, баталгаагүй мэдээлэл;
 - 2.2.8. зээл, төлбөрийн мэдээлэлтэй хамааралгүй хэрэглээ болон худалдан авалтын мэдээлэл;
 - 2.2.9. Монгол Улсын Үндсэн хууль, Зээлийн мэдээллийн тухай хууль болон нууц зохицуулсан хууль зөрчсөн мэдээлэл;
 - 2.2.10. Олон улсын нийтлэг зарчим, стандартыг зөрчсөн мэдээлэл.
- 2.3. Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэгч нь зээлдэгчийн зээлжих зэрэглэлийг тогтоохдоо дараах шаардлагыг баримтална:
 - 2.3.1. Зээлийн онооны загварыг тооцох статистик болон нотолгоонд тулгуурласан аргачлалтай байх;
 - 2.3.2. Зээлийн онооны загварт ашиглах хувьсагч нь эдийн засаг, зээлийн зан төлөвийг илэрхийлэх мэдээлэл дээр үндэслэсэн байх;

- 2.3.3. Шаардлагатай тохиолдолд зээлийн онооны загварын шинэчлэлт болон мэдээллийн шинж чанарт өөрчлөлт оруулах ажлыг зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэгч тухай бүр гүйцэтгэдэг байх;
- 2.3.4. Зээлийн онооны загварын аргачлалыг Монголбанканд тайлагнаж, баримтжуулдаг байх;
- 2.3.5. Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэгч нь зээлийн онооны загварыг шаардлагатай тохиолдолд Монголбанкнаас хүлээн зөвшөөрсөн хөндлөнгийн мэргэжлийн байгууллагаар баталгаажуулдаг байх;
- 2.3.6. Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэгч нь өөрийн зээлжих зэрэглэл тогтоох загвар, аргачлалыг хураангуй байдлаар олон нийтэд нээлттэй ил тод, ойлгомжтой байдлаар албан ёсны цахим хуудсанд байршуулдаг байх;
- 2.3.7. Хэрэглэгч өөрийн мэдээлэл, зээлийн оноонд алдаа байна гэж үзвэл зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдэд гомдол гаргах боломжтой байх;
- 2.3.8. Иргэн, хуулийн этгээд нь өөрийн зээлийн онооны лавлагааг хяналтын зорилгоор авч ашиглах, зээлдэгчийн авсан зээлийн төрөл цөөн байгаа зэрэг нь зээлдэгчийн зээлжих зэрэглэлийн оноог бууруулах үндэслэл болохгүй байх;
- 2.3.9. Иргэн, хувийн өмчит хуулийн этгээдийн зээлийн ангилал давагдашгүй хүчин зүйлээс хамаарч доголдсон бөгөөд зээлийн өр, төлбөрөө бүрэн төлсөн тохиолдолд, түүнчлэн нийгэм, эдийн засгийн бусад нөхцөл байдалтай уялдуулан зээлдэгчийн зээлжих чадварын зэрэглэлийг уян хатан тогтоодог байх;
- 2.3.10. Иргэн, хувийн өмчит хуулийн этгээдийн зээлийн төрөл, зээлийн өр, төлбөрийг бүрэн төлж барагдуулсан хугацаанаас хамаарч зээлдэгчийн зээлжих чадварын зэрэглэлийг уян хатан тогтоодог байх;
- 2.3.11. Зээлдэгч нь өөрийн зээлжих чадварт зэрэглэл тогтоосон зээлийн оноо, тайлбарыг жилд нэг удаа үнэ төлбөргүй авах эрхтэй байх;
- 2.3.12. Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээд нь хэрэглэгчийн мэдээллийн нууцлалыг хадгалж, хамгаалах болон зээлийн онооны загварын эрсдэлийн удирдлагын тогтолцоотой байх;
- 2.3.13. Ашигласан өгөгдөл, зээлийн онооны загварын хувилбар, гаргасан шийдвэрийн (log) бүртгэлтэй байх;
- 2.3.14. Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээд нь нэмэлт өгөгдлийг (цахилгааны төлбөр, үүрэн холбооны төлбөр, торгууль гэх мэт) зээлийн онооны загварт ашиглах боломжтой байх;